



УЛСЫН ДЭЭД ШУУХИЙН
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМД

МОНГОЛ УЛС
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ӨЛГИЙ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР

83120 Өлгий, Өлгий сум, Баян-Өлгий аймаг,

Утас: 18761 7042-3061

2024. 08. 02 № 3/359

танай _____ -ны № _____ -т

Хяналтын журмаар гомдол
гаргах тухай

Т.Өмиржаны нэхэмжлэлтэй Баян-Өлгий аймгийн Өлгий сумын Засаг даргын Тамгын газрын даргад холбогдох төрийн албаны маргаан бүхий захиргааны хэрэгт хариуцагчаар татагдсан Баян-Өлгий аймгийн Өлгий сумын ЗДТГ-ын дарга С.Жадыра би Захиргавны хэргийн давж зөвлөх шатны шүүхийн 2024 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн 221\MA2024\0308 дугаартай магадлалыг эс зөвшөөрч хяналтын журмаар гомдол гаргаж байна.

Давж заалдах шатны шүүх Т.Өмиржаны нэхэмжлэлтэй Баян-Өлгий аймгийн Өлгий сумын ЗДТГ-ын даргад холбогдох төрийн албаны маргаан бүхий захиргааны хэргийн хянан шийдвэрлэхэд хэрэгт цугларсан нотлох баримтуудыг тухайн маргаанд хамаарлтай, ач холбогдолтой, эргэлзээгүй, үнэн зөв талаас нь үнэлээгүйгээс нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан хууль зүйг үндэслэл мутуй шийдвэр гаргасан явдалд гомдолтой байна.

Анхан шатны шүүх Т.Өмиржаны нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн дараах хууль тогтоомжид нийцсэн гэж үзэж байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т "сул орон тоо" гэж төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаалаас нь бууруулсан, төрийн албанаас чөлөөлсөн, халсан, өөр албан тушаалд сонгогдсон, томилогдсон, эсхүл төрийн жинхэнэ албан хаагч нас барсны улмаас тухайн албан тушаалын орон тоо суларсан байхыг", Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн албаны шалгалт өгөх болзول болон шатлан дэвшиүүлэх, сонгон шалгаруулах журам"-ын 1.1-т "Төрийн захиргаа, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захиргачийг сонгон шалгаруулж нэр дэвшиүүлэх, төрийн жинхэнэ албаны сул орон тоог нөхөх шалгalt зохион байгуулах, төрийн жинхэнэ албаны ерөнхий болон тусгай шалгalt өгөх болзол, шатлан дэвшихтэй холбогдсон харилцааг хуульд өөрөөр заагаагүй бол энэхүү журмаар зохицуулна" гэж тодорхойлсон байна.

Төрийн үйлчилгээний албан тушаал нь төрийн захиргааны албан тушаал болон өөрчлөгдсөн энэ тохиолдлыг төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх албан тушаалын шинэ сул орон тоо бий болсон гэж үзэх бөгөөд сул орон тоог нөхөх асуудлыг Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-т "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий этгээд доор дурдсан журмын дагуу уг орон тоог нөхнэ", 27.1.2-т "төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоог гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас", 27.1.3-т "төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоог энэ хуулийн 27.1.2-т заасны дагуу нөхөх боломжгүй бол төрийн албан хаагчийн

нөөцөд байгаа иргэдээс", 33 дугаар зүйлийн 33.12-т "...Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт өгөх болзол, журам, төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журмыг Засгийн газартай зөвшилцэн төрийн албаны төв байгууллага батална" Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын Наймын 8.2-т "Төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх, туслах албан тушаалын сул орон тоог дараах дарааллаар сонгон шалгаруулж нөхнө", 8.2.1-т "тухайн байгууллага болон холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас" 8.2.2-т" энэ журмын 8.2.1-д заасны дагуу нөхөн боломжгүй бол төрийн жинхэнэ албаны нөөцөд байгаа иргэдээс" гэж нарийвчлан зохицуулжээ.


Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-т "Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх, төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулах зорилгоор төрийн албаны мэргэшлийн шалгалтыг авна", 33.2-т "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албаны шалгалт доор дурдсан төрөлтэй байна", 33.2.1-т "ерөнхий шалгалт", 33.2.2-т "тусгай шалгалт", 33.3-т "Ерөнхий шалгалтыг төрийн жинхэнэ алба хаах хүсэлтэй, энэ хуулийн 22.1-д заасан шаардлагыг хангасан иргэн, төрийн үйлчилгээний болон улс төрийн албан хаагаас, тусгай шалгалтыг энэ хуулийн 18.1-д заасан төрийн захирагааны албан тушаалын ангилал хооронд шилжих тохиолдолд болон энэ хуулийн 27.1.3, 33.8-д заасан нөөцөд байгаа иргэдээс тус тус авна" гэж заасан. Гэтэл нэхэмжлэгч Т.Өмндржан нь дээр дурдсан Төрийн албаны тухай хууль болон Төрийн албаны зөвлөлөөс баталсан журамд заасан төрийн жинхэнэ албанд томилогоход тавигдах заасан дээрхи гол шалгуур болох "ерөнхий" болон "тусгай" шалгалтыг өгөөгүй, албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангагүй байх тул түүнийг багийн нийгмийн ажилтны сул орон тоонд төрийн жинхэнэ албаны сонгон шалгаруулалтын шалгалтад иргэд өрсөлдөсний үндсэн дээр хамгийн өндөр оноо авсан иргэд одоо ажиллаж байна.

Монгол улсын 21 аймгийн төвийн бүх сум болон Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 13 багт шинээр бий болсон ба "Төрийн захирагааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинчлэн батлах тухай" Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 487 дугаар тогтоолоор төрийн захирагааны албан тушаалын зэрэглэлд ТЗ-10-аар баталсан тул нийгмийн ажилтны сул орон тоонд төрийн жинхэнэ албаны сонгон шалгаруулалтын шалгалтад иргэд өрсөлдөсний үндсэн дээр хамгийн өндөр оноо авсан иргэд одоо ажиллаж байна.

Иймээс Захирагааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал нь шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байна гэсэн хуулийн заалтыг отг хангагүй, Төрийн албаны тухай хуулийг буруу тайлбарлан төрийн ерөнхий болон тусгай шалгалт өгөөгүй иргэнийг төрийн жинхэнэ албанд заавал ажиллах ёстой гэж дүгнэж байгаа нь учир дутагдалтай, зөвхөн нэхэмжлэгчийн эрх ашиг, сонирхлыг хууль бусаар хамгаалсан маш их алдаатай цаашид төрийн жинхэнэ албан хаагчийн орон тоонд төрийн албаны шалгалт өгөхгүйгээр томилогодох шийдвэр гэж үзэж байна.

Иймд Захирагааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн 308 дугаартай магадлалыг хүчингүйд тооцож хяналтын журмаар гаргасан гомдлыг ханган шийдвэрлэж өгөхийг хүсье.

Хяналтын журмаарт гаргасан гомдлыг хянан хэлэлцэх Улсын дээд шүүхийн Захирагааны хэргийн танхимын шүүх хуралдаанд хариуцагч С.Жадыра би заавал оролцох тул шүүх хуралдааны төвийг урьдчилан мэдэгдэхийг хүсье. Утас-99423395



С.ЖАДЫРА